

ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

“...Иргэн хүн хуулийн төслийн талаар, төрийн шийдвэр гаргах түвшинд үгээ хэлэх болсон явдал нь үнэхээр сайшаалтай сайхан үйл явдлуудын нэг юм. Энэхүү “Иргэний танхим” жирийн иргэдийн дуу хоолойны индэр болж байгаад баяртай байна...”

Иргэн С.Цэндбаатар

“...Иргэдийн оролцоо гэдэг бол иргэдийг оролцуулсан гэх нэр зүүх биш харин чухал санал шийдлүүдийг гаргах гэж буй шийдвэртээ болон үйл ажиллагаандаа тусгадаг байх ёстой. Ийм зорилгоор “Иргэний танхим” байгуулагдаж байгаад баяртай байна...”

Иргэн Д.Ламжав

“...Өндөр настан биднийг төрийн ордонд тэр тусмаа Ерөнхийлөгчийн сууж байсан өрөөнд урьж орууллаа. Их сайхан танхим байна. Тэгээд бидэнд хүүхэд, хөгшид гэж ялгалгүй үг хэлэх, саналаа илэрхийлэх боломж олгож байна. Ийм амархан төрийн хэрэгт оролцож саналаа хэлж байгаадаа итгэж ядан байна...”

Өндөр настан Д.Далхсүрэн

71.1.Байнгын, дэд хороо тодорхой асуудлын талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор дараахь журмаар нээлттэй сонгогч /цаашид “сонгогч” гэх/ зохион байгуулж болно.

/2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн нэмэлтээс.../

“ИРГЭНИЙ ТАНХИМ”-ЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ИРГЭН ТА ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

Иргэн Та хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тухайн нээлттэй хэлэлцүүлэг зарлагдмагц дараах хэлбэрээр санал бодол, байр сууриа илэрхийлж болно. Хэрэв Та нээлттэй хэлэлцүүлгийн хуралдаанд биечлэн ирж оролцохоор шийдсэн бол хэлэлцүүлгийн бүртгэлийн өдөр зарлагдмагц Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”-д хандаж бүртгүүлнэ.

Хаяг:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”-д /Төрийн ордон 373 тоот, Улаанбаатар-12, Монгол Улс/ гэж хаягласан захидлаар,
- Факс: 263486
- Утас: 263489
- irgen@president.mn цахим шуудангаар ирүүлсэн захидлаар,
- www.president.mn/forum цахим хэлэлцүүлэгт саналаа ирүүлэх,
- “Иргэний Танхим”-ын нээлттэй хэлэлцүүлэгт биечлэн ирж оролцох,

Орон нутагт иргэний оролцоог хангах арга замын тухай “Иргэдийн оролцоонд тулгуурласан нутгийн өөрөө удирдах ёс” зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим”-аас эрхлэн гаргалаа. Энэхүү зөвлөмжийг авахыг хүссэн иргэд, байгууллагууд манай хаягаар хандана уу.



“Ард түмний төр юм бол ард түмэндээ эдлэх эрхийг нь өгөөч гэж би та бүхнээс дахин гуйя. Хуулиар булаасан эрхийг чинь хуулиар буцааж өгнө гэсэн үгийг манай иргэд, орон нутгийнхан дахиад хэдэн чуулган дамжиж сонсох ёстой юм бэ? Дахиад хэдэн жил тэд эрхээ ирэхийг харж шилний цаанаас чихэр долоох юм бэ?”

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн байнгын ажиллагаатай анхны ардчилсан парламент үүсэж хөгжсөний 20 жилийн ойд зориулан УИХ-ын хүндэтгэлийн чуулганд хэлсэн үгээс... /2010.10.20/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “ИРГЭНИЙ ТАНХИМ”



“Иргэний танхим”-ыг байгуулахад арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлсэн ХБНГУ-ын Элчин сайдын яам, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, АНУ-ын Азийн сан, “Нээлттэй нийгэм” форумын хамт олонд гүн талархал илэрхийлье.

Иргэн та “Иргэний танхим”-ынхаа эзэн нь байж хүмүүнлэг иргэний нийгэм байгуулах их үйлсэд хамтран ажиллахыг урьж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх
“Иргэний танхим”-ын ажлын алба

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

www.president.mn



“АРДЧИЛСАН ТӨР ИРГЭДДЭЭ НЭЭЛТТЭЙ”

“Иргэн” төвтэй төрийг төлөвшүүлэхэд Иргэн Таны оролцоо юу юунаас илүү үнэтэй байх болно.

УЛААНБААТАР ХОТ
2011 он

Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ” хэмээн хуульчлан баталгаажуулсан байдаг. Үндсэн хуулийн энэ заалтыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 2009 оны 12 дугаар сарын 15-нд “Иргэний танхим”-ыг санаачлан байгуулсан болно.

Иргэний оролцоогүй иргэний нийгэм гэж байж болохгүй, хүний оролцоогүй хүний нийгэм гэж байж болохгүй.

“Иргэний танхим”-ыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн хэлсэн үгээс... /2009.12.15/



■ Таны оршин сууж буй хот, хороо, сум, багийн чинь өдөр тутмын амьдралтай холбоотой тулгамдсан олон асуудал ужигран хуримтлагдсаар байх болно. Тухайлбал бидний эргэн тойронд хог хаягдал овоорон, байгаль орчин сүйрч, хууль дүрмийг хэн дуртай нь зөрчсөөр л байх болно.

■ Энэ бүхнийг шийдвэрлэхэд эрх ашгаа хамгаалахад хууль шударга ёсыг сахиулахад иргэн Та заавал оролцох үүрэгтэй, бас эрхтэй.

■ Иргэд төрийн үйл хэрэгт оролцсоноороо шийдвэр гаргагчид дур зоргоороо авирлах үйлдлийг таслан зогсооно. Төр, засаг цөөн бүлэг хүмүүст бус ард түмнийхээ нийтлэг, хууль ёсны эрх ашигт үйлчлэх эрхэм үүргээ биелүүлж эхлэнэ.

*** Иргэдээсээ асуу * Иргэдээ сонс * Иргэдээрээ шийдүүл**



ХУУЛИЙН ТӨСЛҮҮДЭЭС...

“Иргэний Танхим” байгуулагдсан нэг жил гаруйн хугацаанд 23 удаа нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэд, төр, засгийн шийдвэр гаргагч түвшинд ажиллагсад болон иргэний нийгмийн төлөөлөл болох 1826 иргэн оролцож тодорхой саналууд дэвшүүлсэн байна.

Үүнээс дурдвал:

- “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт **155 иргэн**
- “Шүүхийн тухай” Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт **65 иргэн**
- “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын тэтгэлэг, тэтгэмж нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт **122 иргэн**
- “Төсвийн тухай” Монгол Улсын хуулийн төслийн хэлэлцүүлэгт **200 иргэн**
- “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт **129 иргэн**
- “Монгол Улсын иргэн би” сэдэвт хүүхдийн хэлэлцүүлэгт **85 хүүхэд**
- “Монголын уламжлалт сэтгэлгээ ба арга билгийн ухааны үндэс” хичээлийн үндсэн агуулгын хэлэлцүүлэгт **119 иргэн**
- “Иргэдийн Ардчилал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгт **93 иргэн**
- Сумын дүрмийн төслийн нээлттэй хэлэлцүүлэгт **82 иргэн**
- “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын тэтгэлэг, тэтгэмж нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлэгт **45 иргэн**
- Архи, тамхи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодисын хор аюул ба хүний аюулгүй байдал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгт **68 иргэн**
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хот байгуулалт, төлөвлөлтийг боловсонгуй болгох асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт **42 иргэн**
- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын цалин тэтгэлэг, тэтгэмж, нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдэд танилцуулах, санал солилцох уулзалт хуралдаан /2010.12.01/
- “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэг /2011.01.17/

Иргэний танхимд зохион байгуулагдсан нээлттэй хэлэлцүүлгүүдийн мэдээллийг www.president.mn сайтаас үзнэ үү!

Ардчилсан нийгэмд төрийн үйл хэрэгт иргэд төлөөллийн болон шууд хэлбэрээр оролцдог.

Төлөөллийн оролцооны хэлбэр нь сонгууль бөгөөд төрийн болон орон нутгийн эрх барих дээд байгууллагад иргэд өөрсдийгөө төлөөлж асуудлыг шийдэх хүмүүсийг сонгодог.

Харин иргэд сонгуулиас бусад үед шийдвэр гаргах бүхий л түвшинд хэрхэн оролцох вэ? Үндсэн хуулиар олгогдсон ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхээ хэрхэн эдлэх вэ гэсэн асуулт урган гарч байна.

Энэ эрхээ эдлэх боломжийг “Иргэний танхим” Танд олгоно.

Иргэд хэн нэгнээр дамжуулалгүйгээр өөрийн санал бодол, байр сууриа илэрхийлэхээр “Иргэний танхим”-ын нээлттэй хэлэлцүүлэгт оролцон асуудлыг хамтран шийддэг. Гаргасан шийдвэрээ төрийн болон орон нутгийн эрх барих дээд байгууллагын шийдвэр болгохоор хүргүүлж, хэрэгжилтийг нь хянадаг.

■ Иргэд бид төрийн шийдвэр гаргах үйл явцыг УИХ, Засгийн газар, нам, орон нутгийн удирдлага зэрэг цөөн тооны хүмүүст хамаатай, иргэд биднээс хол хөндий зүйл хэмээн ойлгосоор байвал төрийн хүнд суртал, авлига хээл хахууль, ёс бус үйл ажиллагаа газар авсаар байх болно.



Зургийг С.Цогтбаатар

Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо орон нутагт нэмэгдэхийн хэрээр Монгол оронд шууд ардчиллын хөрс суурь бүрдэнэ.

Иргэний оролцоо нь ямар нэг улстөр, бизнесийн бүлгийн ашиг сонирхолыг илэрхийлэхгүй.

Харин жирийн иргэдийн өдөр тутмын амьдрал, амьжиргаатай холбоотой тодорхой асуудлуудыг бүх шатны шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хүргэж иргэдийн нийтлэг эрх ашгийг хангахад нөлөөлж төр, иргэний амьд холбоог үүсгэнэ.

Энэ амьд харилцааг үүсгэн төлөвшүүлэхээр “Иргэний танхим” иргэд, төр засгийн хооронд гүүр болон ажиллаж байна. Ингэснээр иргэдийн саналыг төрийн бодлого шийдвэрт тусгуулах нөхцлийг бүрдүүлэх болно.



НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАДНА САЛБАР ХУРАЛДААНУУД 63 УДАА ХУРАЛДАЖ 2548 ИРГЭН ОРОЛЦООД БАЙНА.